

Оюу Толгойг хэн сайн мэдэх вэ?

Сайн байцгаана уу? Юуны өмнө миний эссэг уншиж буй Оюу Толгой компаний ах, эгч нартаа энэ өдрийн мэндийг хүргэе.

Оюу Толгой

Оюу Толгой гэдэг нэр Монголчууд бидний амьдралд сонсогддог болоод удаж байгаа төдийгүй мэдэхгүй хүн гэж үгүй бизээ. Телевиз, радио, цахим ертөнц, сонин сэтгүүл гээд бүхий л мэдээллийн хэрэгслээр өглөө, оройгүй л эерэг, сөрөг янз бүрийн мэдээлэл бидэнд хүрч байна. Харин хүмүүс бид өөр өөрсдийн өнцгөөс хүлээж авдаг. Миний хувьд “Оюу Толгой” гэдэг нэрийг амралтаараа ирээд ажлынхаа сонин сайхныг хуваалцдаг эгчийнхээ ярианаас л сонсдог болсон нь энэхүү эссэг бичихэд нөлөөлсөн юм.

Миний эгч энэ компаний мянга мянган ажилтнуудын нэг. Эгчийн амнаас “аюулгүй ажиллагаа” гэдэг үг гарах нь олонтаа, нэгэн удаа би таны ажлын хамгийн чухал зүйл нь юу вэ гэж асуухад “аюулгүй ажиллах” гэж хэлсэн юм. Тус компанид ажилладаг олон мянган хүн ямар нэгэн гэмтэл бэртэлгүйгээр гэртээ эргэж ирэхийг хэлнэ гэж тайлбарласан нь тэр талаар огт мэдлэггүй байсан надад маш чухал зүйл гэдгийг мэдрүүлсэн. Үүнээс л би алхам тутамдаа харууцлагатай байх ёстой гэдгийг ойлгосон юм.

Оюу Толгой - Олны хүч

Миний эх орны их бүтээн байгуулалтад өөрсдийн оюун ухаан, ур чадвар, хүч хөдөлмөрөө зориулан байгаа 11151 Монголчууд, дэлхийн өнцөг булан бүрээс ажиллахаар ирсэн гадаадын мэргэжилтэн, ажилтнуудгүйгээр Оюу Толгой компанийг төсөөлөхийн аргагүй. Нэг Монгол ажилчны ард дунджаар 3 хүн байна гэж авч үзэхэд 30000 гаруй иргэн идэх хоол, өмсөх хувцас, орон байр, сурч хүмүүжих цэцэрлэг, сургуультай байна гэдэг бол бага тоо бишээ гэж би бодож байна.

Оюу Толгой – Оюуны салбарт

Оюу Толгой компани урлаг соёл, эдийн засаг, хөдөө аж ахуйн, боловсрол, эрүүл мэнд гээд бүхий л салбарт өөрсдийн хувь нэмрээ оруулдаг олон жишээ байдгийг бид мэднэ. Тухайлбал, ирээдүйн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх, Монголын ирээдүй болсон олон залууст тэтгэлэг олгох, мэргэжлийн боловсролын салбар дахь 168 тэрбум төгрөгийн зарцуулалт зэргийг харахад боловсролын салбарт маш том хөрөнгө оруулалт оруулж байгааг харуулж байна. Шилдэг оюутан залуусын хувьд тэтгэлэг авна гэдэг бол хамгийн үнэ, цэнэтэй хөрөнгө оруулалт гэж би боддог.

Эцэст нь хэлэхэд Оюу Толгой компанийг тойрсон муу муухай, худал хуурмаг бүхэн арилж, Монгол хүн бүрийн бахархал болсон дэлхийн хэмжээний хамгийн том бүтээн байгуулалт байх болно гэдэгт би итгэлтэй байна. Монголын уудам хөх тэнгэр шиг тийм сайхан гэрэлт ирээдүйн нэг хэсэг нь Оюу Толгой компани байгаасай гэсэн ерөөлөөр энэхүү эссэгээ өндөрлөж байна.

Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье!